

## **Сэгсрэлт /Turbulence/**

Агаарын хөлөг нисэх явцад салхины хурд болон чиглэлийн гэнэтийн огцом өөрчлөлтөнд орж онгоцонд нөлөөлөх үзэгдлийг **сэгсрэлт гэж нэрлэдэг.**

Сэгсрэлтийг үүсэх шалтгаанаар нь **3** ангилдаг.

1. **Дулааны гаралтай сэгсрэлт** - Газрын гадаргын жигд бус халалттай холбоотойгоор агаарын өгсөх уруудах чигийн хөдөлгөөнөөр үүснэ.
2. **Механик гаралтай сэгсрэлт** - Газрын гадарга орчмын уул нуруу, байшин барилга зэрэг томоохон саад, тотгорыг агаарын урсгал давах буюу тойрон гарахад үүсэх салхины хуйлралтай холбоотой.
3. **Динамик гаралтай сэгсрэлт**- Хийн мандал дахь салхины шилжлэгтэй холбоотойгоор үүсдэг. Дотор нь 4 хувааж үздэг. Үүнд:
  1. Инверси
  2. хийн мандлын дулаан, хүйтэн фронтын
  3. цэлмэг тэнгэрийн (CAT)
  4. агаарын хөлгийн арын дагалдах хуйлрал (wake turbulence).

**Инверси:** Инверсийн хилийн доор салхигүй намуун байх ба хилийн дээр хүчтэй салхитай байдаг. Иймд инверсийн хилийг өнгөрсний дараа хөөрөх үед арын салхины хурд огцом ихсэж, буух үед угтах салхины хурд огцом багасдаг учир нислэгийн өндөр алдах аюултай байдаг.

**Дулаан, хүйтэн фронтын сэгсрэлт:** Дулаан хүйтэн агаарын зааг дээр үүл, хур тунадас, цаг агаарын бусад үзэгдлүүдтэй хамт ажиглагдана.

**Цэлмэг тэнгэр дэхь сэгсрэлт нь /clean air turbulence - CAT/:** Конвекцийн хөдөлгөөн ба сэмжин /CI/ үүлний нөлөөгөөр CAT үүсдэг. Мөн CAT нь 7-10км өндөрт салхи, температурын орны огцом өөрчлөлттэй холбоотой үүсдэг.

**Агаарын хөлгийн арын дагалдах хуйлрал:** Агаарын хөлгийн арын дагалдах сэгсрэлт нь агаарын хөлөг зурвасаас хөөрөхөөр хурд авах үед далавчинд өргөх хүч бий болж, агаарын хуйларсан урсгалыг үүсгэдэг.

**Сэгсрэлтийг эрч хүчээр нь :**

1. **Сул хүчтэй сэгсрэлт** – Хааяа үл мэдэг сэгсрэнэ
2. **Дунд зэргийн хүчтэй сэгсрэлт** – Дээш, доош байн байн хэлбэлзэнэ
3. **Хүчтэй сэгсрэлт** – Доргилт их хэмжээтэй ажиглагдах ба огцом ганц нэг шидэлт илрэнэ.
4. **Онц хүчтэй** – Огцом хүчтэй сэгсрэлтийн үед онгоц хэт ачаалалд орж, нислэгийн өндөр, чиглэл ихээр хазайж жолоодлого алдагдана.

Урьдчилсан мэдээнд **дунд хүчтэй сэгсрэлт /MOD TURB/, хүчтэй сэгсрэлт/SEV TURB/-ийг мэдээлдэг.**